

**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ЗААЛ, ТАЛБАЙГ
НЭЭЛТТЭЙ БОЛГОХ ТООЦОО, СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА**

2024 оны 04 дүгээр сарын 09

Улаанбаатар хот

1.Судалгааны зорилго:

1.1.Нийслэлийн иргэдийг эрүүл чийрэг байлгах, тэднийг биеийн тамир, спортоор хичээллэх болон тамирчдын амжилтыг ахиулах таатай орчин нөхөцлийг бүрдүүлж байгаа Биеийн тамир, спортын барилга байгууламж, заал, талбайг нээлттэй болгох тооцоо судалгаа гаргаж хүртээмжийг тодорхойлоход гол зорилгоо болголоо.

2.Судалгааны зорилт:

2.1.Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа хүүхэд залуучууд, иргэдэд зориулсан биеийн тамир, спортын барилга байгууламжийн талаарх нэгдсэн судалгааг гаргах

2.2.Нийслэлийн иргэдэд үйлчилж байгаа спортын барилга байгууламжийн хүртээмжийг тодорхойлох.

2.3.Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын заал болон спортын зориулалтын гадна талбайг нээлттэй болгох тооцооллыг хийж, тайлбар гаргах

3.Судалгаанд хэрэглэсэн арга, аргачлал:

3.1.Бид судалгааныхаа ажилд онолын судалгааны арга, анкет бүртгэлийн арга, математик, статистикийн энгийн аргууд, задлан шинжилж нэгтгэн дүгнэх аргуудыг ашиглалаа.

3.2.2004 онд Монгол улсын дэд бүтцийн яам, Стандарт хэмжил зүйн газраас баталсан "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм, БНБД 30-01-04 стандартын зөвлөмжийн 13-р хавсралтын 15-д заасан заалтыг үндэслэж нийслэлийн иргэдэд үйлчилж байгаа спортын барилга байгууламжийн хүртээмжийг тодорхойлсон.

Хүснэгт-1

Хот, суурины биеийн тамир, спортын байгууламж, цогцолборын стандарт:

Барилга байгууламжийн нэр	Хэмжих нэгж	Үндэслэл	Ангилал	Норматив хэмжээ /Нэг мянган хүнд/	Эдэлбэр газрын хэмжээ
1	2	3	4	5	6
Биеийн тамир, спортын байгууламж	М ² шалны талбай	Хот сууринд төлөвлөнө	Хорооллын чанартай биеийн тамир, эрүүлжүүлэлтийн танхим /хотын чанартай/ Нийтийн хэрэгцээний спорт танхим	70-80 60-80	1000 хүнд 0,7-0,9 га
Тайлбар: Нягтруулах зорилгоор Ерөнхий боловсролын сургууль, соёл амралтын байгууллагын спорт, биеийн тамирын танхимтай нэгтгэж болно.					

4.Судалгааны хамрах хүрээ:

4.1.Судалгаанд нийслэлийн нийт суурин хүн ам, 9 дүүргийн 204 хороонд байрлах төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, ерөнхий боловсролын сургуульд

харьяалагдах спортын барилга байгууламж, заал, усан бассейн спортын зориулалтын талбайг хамруулсан болно.

Судалгааны 1-р зорилт: Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа хүүхэд залуучууд, иргэдэд зориулсан биеийн тамир, спортын барилга байгууламжийн талаарх нэгдсэн судалгааг гаргах

**Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа
спорт заалны тоон мэдээлэл**

Хүснэгт-2

№	Дүүрэг	Нийт спорт заалны тоо	Заалны талбайн хэмжээ (м2)	ЕБС-ийн спорт заал (тоо)	ИДС-ийн спорт заал (тоо)	Төрийн болон төрийн бус байгууллагын спорт заал (тоо)	Усан бассейн (усан сан) (тоо)
1	Баянгол	49	14452	25	10	9	3
2	Баянзүрх	74	27141	47	12	11	8
3	Багануур	10	4320	6	0	3	1
4	Багахангай	3	1152	3	0	1	0
5	Сүхбаатар	46	7954	29	9	5	9
6	Сонгинохайрхан	48	13600	24	3	12	1
7	Хан-Уул	87	18966	29	7	39	12
8	Чингэлтэй	27	8613	18	1	7	1
9	Налайх	11	5096	6	0	3	1
	Улаанбаатар	355	101294	187	42	90	36

Нийслэлийн хэмжээнд 2024 оны эхний улирлын байдлаар нийт спортын 355 спортын заалтай барилга байгууламж ашиглагдаж байна. Үүнд:

1. Сургалтын зориулалттай их, дээд сургуулийн заал 42, албан газруудын заал 90, ЕБС-ийн спорт заал 187 байна.
2. Нийслэлийн иргэдэд үйлчлэх зориулалттай усан бассейн /усан сан/ 36 байна. Дээрх спортын барилга, байгууламжуудаас олон улсын тэмцээн уралдаан зохион байгуулах зориулалт бүхий 5045 хүний суудалтай спорт цогцолбор 1, 2500 хүний суудалтай бөхийн өргөө 1 ажиллаж байна. 250-2500 хүний суудалтай 18 спортын ордон үйл ажиллагаа явуулж байна

Судалгааны 2-р зорилт: Нийслэлийн иргэдэд үйлчилж байгаа спортын барилга байгууламжийн хүртээмжийг тодорхойлох.

Нийслэлийн хэмжээнд байгаа спортын барилга байгууламж, заал, талбайн тоог гаргаж нийслэлийн хүн амын нягтаршилд харьцуулан гаргаж 2023 онд хүүхэд залуучууд, нийт иргэдэд үйлчлэх спортын барилга, байгууламжийн хүртээмж 1000 хүнд 63,5 м² -д хүрсэн байна гэж тодорхойллоо.

Нийслэлийн нийт хүн ам. /2022 оны статистик/ хүснэгт-3, график-1


№	Дүүргүүд	Суурин хүн амын тоо / мян. х/
1	Улаанбаатар	1596.3
2	Багануур	29.3
3	Багахангай	4.4
4	Баянгол	246.9
5	Баянзүрх	408
6	Налайх	39.6
7	Сонгинохайрхан	342.1
8	Сүхбаатар	142.4
9	Хан-Уул	238.5
10	Чингэлтэй	144.2



Нийслэлийн хэмжээнд байгаа спортын барилга /2023 он/ хүснэгт-4

№	Дүүрэг	Суурин хүн амын тоо / мян. х/	Нийт спортын заал /усан бассейн/-тай барилгын тоо	Талбайн хэмжээ /м ² шалны талбай/	1000 хүнд ногдож байгаа талбай	1000 хүнд ногдох норматив /70-80 м ² /
1	БНД	29.3	10	4320	147	70-80 м ²
2	БХД	4.4	3	1152	261	70-80 м ²
3	БГД	246.9	49	14452	58.5	70-80 м ²
4	БЗД	408	74	27141	66.5	70-80 м ²
5	НД	39.6	11	5096	128.6	70-80 м ²
6	СХД	342.1	48	13600	39.7	70-80 м ²
7	СБД	142.4	46	7954	55.8	70-80 м ²
8	ХУД	238.5	87	18966	79.5	70-80 м ²
9	ЧД	144.2	27	8613	59.7	70-80 м ²
10	УБ	1596.3	355	101294	63.5	70-80 м ²

График-2



Гарч буй үр дүн: Нийслэлийн хэмжээнд нийт 355 спортын заалтай барилга байгууламж байгаа бол нийслэлд 1596.3 мянган хүн ам оршин сууж байна. Монгол Улсын Дэд бүтцийн яам, Стандарт хэмжил зүйн газраас баталсан “Хот, тосгоны төлөвлөлт,

барилгажилтын норм ба дүрэм, БНБД 30-10-04 стандартын зөвлөмжийн дагуу спорт заалны шалны талбайгаар тооцоход нийт 101294м² хэмжээтэй байгааг 1000 хүнд харьцуулан тооцож үзэхэд 63,5 м² талбай оногдож байна. Энэ үзүүлэлт нь нормд заасан хэмжээнээсээ 7,5-12,5 м² талбайгаар дутуу байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургуулиудын жагсаалт

хүснэгт-5

№	Дүүрэг	Төрийн өмчийн сургууль	Төрийн бус өмчийн сургууль	Нийт
1	Баянгол	21	29	50
2	Баянзүрх	35	30	65
3	Багануур	3	1	4
4	Багахангай	1	0	1
5	Налайх	5	3	8
6	Сүхбаатар	26	24	50
7	Сонгинохайрхан	27	8	35
8	Чингэлтэй	19	9	28
9	Хан-Уул	30	25	55
10	Нийт	167	129	296

Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын спортын гадна талбайн нэгтгэсэн мэдээлэл (2021 оноор)

хүснэгт-6

№	Дүүрэг	Ерөнхий боловсролын сургуулийн тоо	Спортын гадаа талбай		Тохижуулах шаардлагатай спортын гадаа талбайн тоо	Сургуулийн эзэмшлээс хасагдсан талбайн тоо	Зориулалтын бусаар ашиглаж буй гадна спортын талбайн тоо	
			Спортын гадаа талбайтай сургуулийн тоо	Спортын гадаа талбайгүй сургуулийн тоо				
1	БГД	Төрийн	20	18	2	16	2	3
		Хувийн	29	3	26	3	0	0
2	БЗД	Төрийн	33	19	14	18	3	0
		Хувийн	28	9	19	6	1	0
3	БНД	Төрийн	3	3	0	4	0	0
		Хувийн	1	0	1	0	0	0
4	БХД	Төрийн	1	1	0	1	0	0
		Хувийн	0	0	0	0	0	0
5	НД	Төрийн	5	5	0	5	0	0
		Хувийн	3	1	2	1	0	0
6	СБД	Төрийн	26	10	16	6	1	0
		Хувийн	24	0	24	0	0	0
7	СХД	Төрийн	24	10	14	11	0	1
		Хувийн	8	0	8	0	0	0
8	ХУД	Төрийн	18	15	3	9	1	0
		Хувийн	25	5	20	0	0	0
9	ЧД	Төрийн	18	15	3	13	0	1
		Хувийн	9	0	9	0	0	0
10		Бүгд	275	114	161	93	8	5
11	Нийт	Төрийн	148	96	52	83	7	5
		Хувийн	127	18	109	10	1	0

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЗОРИУЛАЛТЫН ТАЛБАЙН УРЬДЧИЛСАН МЭДЭЭЛЭЛ
(ЕБС-ИАС БУСАД БАЙГУУЛЛАГА)**

хүснэгт-7

№	Дүүрэг	Байгууллагын нэр	Хаяг байршил	Спортын төрөл					Талбайн хэмжээ м ²
				Хөл бөмбөг	Сагсан бөмбөг	Волейбол	Софт теннис	Бусад	
1	БНД	ЗДТГ	1-р хороо	1					4950 м ²
2		Үндэсний сур	1-р хороо					1	3800 м ²
3	БЗД	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн	26-р хороо	1	1	1	1	2	4900 м ²
4		15-ын талбай	4-р хороо	1	1		1		6900 м ²
5	СХД	Хөл бөмбөг	17 хороо	1					1024 м ²
6		Найрамдал зуслан					2		500 м ²
7	ЧД	Хайрхан хөгжлийн төв	ЧД 19-р хороо дээд салхит	1	2		2		7776 м ²
8	НД	"Тэлмэн" констракшин	7-р хороо Шинэ Налайх хороолол	1					4800 м ²
9					1				
10	ХУД	Төв цэнгэлдэх хүрээлэн	15-р хороо	1					40x20, 80x40, 103x64
11		Хөлбөмбөгийн холбооны гадна Мазаалай	15-р хороо	2					103x63, 40x25
12		Олимпийн хорооны зүүн талд	15-р хороо				4		1000 м ²
13		Хасу мега старс спорт цогцолбор	13-р хороо				2		500 м ²
14		Яармаг\Морин тойруулга\	8-р хороо				3		800 м ²
15		ISU	18-р хороо		1				103x64
16	БГД	ТЭЦ-4	ЭГудамж 20-р хороо	1					7140 м ²
Нийт-33 талбай			16 байршил	12	4	1	15	1	

Тайлбар: Спортын зориулалтын талбай гэж спортын тэмцээн уралдаан зохион байгуулах, хичээл, сургалт зохион байгуулах зориулалт бүхий стандарт шаардлага хангасан талбайг хэлнэ.

Нийслэлийн хэмжээнд нийт 147 спортын зориулалтын талбай байгаа бөгөө 80-90 хувь нь хүйтний улиралтай холбоотойгоор иргэдэд үйлчлэхгүй хаалттай байна. Дулааны улиралд 30 гаруй талбай иргэд, хүүхэд багачуудад нээлттэй ажиллахад бэлэн байна.

Харин ерөнхий боловсролын сургуулиудын гаднах спортын талбайд дулааны улиралд сурагчдын биеийн тамирын хичээл, сургалт, секц дугуйлан хичээллэхээс бусад цаг үед нээлттэй биш байдаг.

Нийслэлийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн нийт 114 спортын талбай байгаагаас 67 талбай нь стандарт шаардлага хангаж байгаа гэсэн урьдчилсан мэдээлэлтэй байгаа бол бусад талбайн тухайд тохижилт бүрэн хийгдээгүй, засварлах шаардлагатай талбайнууд багтаж байна.

Судалгааны 3-р зорилт: Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын заал болон спортын зориулалтын гадна талбайг нээлттэй болгох тооцооллыг хийж, тайлбар гаргах

Нийслэлийн хэмжээнд ашиглагдаж байгаа 355 спортын заалтай байгууллагуудаас их дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагуудын 177 байгууллагын спорт заал нээлттэй байгаа бөгөөд төлбөрт үйлчилгээ явуулж олсон орлогоороо ажиллах хүч, ашиглалтын зардал болон засвар үйлчилгээний зардлаа шийдвэрлэж байна.

Мөн ерөнхий боловсролын сургуулиудын спорт заал ашиглалтын тухайд 2017 оноос өмнө Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 98 дугаар тушаалын 2 дахь заалтын дагуу хичээл, сургалт, секц дугуйлангаас бусад хэлбэрээр тодруулбал иргэд, аж ахуй нэгж байгууллагыг гэрээгээр төлбөртэй үйлчилгээ явуулахыг хориглосон байсан.

Дээрх асуудлыг Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 20217 онд холбогдох байгууллагуудад асуудлыг тавьж 2017 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/333 дугаар тушаалаар шийдвэрлэж өгсөн тул байгууллага, иргэдэд нээлттэй байдлаар гэрээгээр спорт зааланд хичээллэх үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон.



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН РУШААХ

2017 оны 11 сарын 22 өдөр

Төрлийн А/333

Улаанбаатар хот

**Биеийн тамирын заалны
ашиглалтын тухай**

Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 1 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь


1. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн чиг үүрэг, хичээл, хичээлээс гадуурх сургалт (секц, дугуйлан)-ын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй, суралцагчийн эрх ашгийг хохироохгүйгээр хичээл, сургалтын бус цагаар сургуулийн биеийн тамирын заалыг аж ахуйн нэгж байгууллага, иргэнд гэрээгээр ашиглуулж нэмэлт орлого олохыг төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт зөвшөөрсүгэй.

2. Биеийн тамирын заалыг гэрээний үндсэн дээр бусдад ашиглуулах, олсон орлогыг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусган зарцуулах шийдвэр гаргах, тайлагнах, хяналт тавихад хамт олны эрэлцээг хангаж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосүгэй.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, зарцуулах, тайлагнах журмын төслийг 2018 оны I сард батгаан боловсруулж батлуулах арга хэмжээ авахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Нансалмаа/-г үүрэг болгосүгэй.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Хураамж авахыг хориглох тухай" 2008 оны 98 дугаар тушаалын 2 дахь заалтыг хүчингүй болгонд тооцсүгэй.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

03 1961

Нийслэлийн хэмжээнд нийт 147 спортын зориулалтын талбай байгаа бөгөө 80-90 хувь нь хүйтний улиралтай холбоотойгоор иргэдэд үйлчлэхгүй хаалттай байна. Дулааны улиралд 80 гаруй спортын зориулалтын талбай иргэд, хүүхэд багачуудад нээлттэй ажиллахад бэлэн байна.

Харин ерөнхий боловсролын сургуулиудын гаднах спортын талбайд дулааны улиралд сурагчдын биеийн тамирын хичээл, сургалт, секц дугуйлан хичээллэхээс бусад цаг үед нээлттэй биш байдаг. Нийслэлийн хэмжээнд 296 ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаа явуулж байгаагаас 114 сургууль нь спортын талбай байдаг боловч 67 талбай нь стандарт шаардлага хангаж байгаа бол бусад талбайн тухайд тохижилт бүрэн хийгдээгүй, засварлах шаардлагатай талбайнууд багтаж байна.

Нийслэлийн Боловсролын газраас биеийн тамирын гадна талбайн гүйлтийн зам, хиймэл зүлэг болон бусад тоноглолын бүрэн бүтэн байдалд үзлэг хийж аюулгүй байдлыг хангах ажлыг яаралтай зохион байгуулж стандарт шаардлага хангаж байгаа талбайнуудыг нээх, стандарт шаардлага хангахгүй байгаа биеийн тамирын талбайг засаж тохижуулах талаар тодорхой үр дүнтэй ажил хийх шаардлагатай байна.

Мөн Нийслэлийн Боловсролын газраас биеийн тамирын хичээл, сургалтын чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор биеийн тамирын заал, биеийн тамирын гадна талбайн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах нь чухал байна.

СУДАЛГАА ГАРГАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

НЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА



Г.БЯМБАСАЙХАН

Ж.ГАНБОЛД